



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/470

Булган сум

Газар эзэмших эрх хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Батхуяг (ГЮ71021070)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 6 дугаар гудамж 602 тоотод байршилтай 6308003783 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 5000 м2 газраас 3750 м2 газрыг Р.Батхишиг (ГЮ74041261)-т, 1250 м2 газрыг Б.Нямбат (ГЙ78012611)-д тус тус газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлсүгэй.

2. Р.Батхишиг, Б.Нямбат нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны Б/165 дугаар захирамжийн Б.Батхуягтай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

